



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.05 № 02/Н  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ  
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНЫ ДАРГА Ч.ДАШДАВАА  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Монгол Ардын намын хорооны ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (13 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Монгол Ардын намын хороонд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт 13 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



# МОНГОЛ АРДЫН НАМ

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН  
ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН  
ХӨТӨЛБӨР**



**АГУУЛГА:**

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 1.1. ОРЛОГТОЙ ИРГЭН
- 1.2. ЭРҮҮЛ ИРГЭН
- 1.3. ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛ
- 1.4. ТОГТВОРТОЙ АМАР АМГАЛАН ГЭР БҮЛ
- 1.5. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР
- 1.6. ЗАЛУУЧУУДЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР
- 1.7. ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙГ ДЭМЖИХ  
ЧИГЛЭЛЭЭР
- 1.8. АХМАДУУДАД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР
- 1.9. ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР

**ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

- 2.1. МАЛ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН, ҮЙЛДВЭРЛЭЛ
- 2.2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
- 2.3. ТӨСӨВ САНХҮҮ

**ГУРАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

- 3.1 БАТАЛГААТ УНДНЫ УС
- 3.2 ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

**ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ, СУМЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТЫН БОДЛОГО:**

**ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО:**





## **МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ:**

- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ МУ-ын алсын хараа – 2050 хөгжлийн хөтөлбөр
- ✓ Хөгжсөн Хөвсгөл 2030 хөтөлбөр
- ✓ Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
- ✓ 2024 оны УИХ болон аймгийн ИТХ-ын сонгуульд МАН-аас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр.
- ✓ Цэцэрлэг сумын ард иргэдийн санал.

### **✓ УРИА: “ЦЭГЦТЭЙ БОДЛОГО ЦЭЦЭРЛЭГ НУТГИЙН ХӨГЖИЛ”**

**Зорилго:** Сумынхаа хүн амын амьдрах, хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин нөхцлийг бүрдүүлж, ил тод, нээлттэй, хариуцлагатай засаглалтай, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангасан, өөрийгөө тэтгэсэн тогтвортой эдийн засаг бүхий жишиг сум болж, орон нутгынхаа хөгжлийг хурдасгаж, иргэдийнхээ амьдралын чанарыг сайжруулахад оршино.

**Үр дүн:** Ажилтай, орлоготой, бүтээн байгуулалттай, хамтын ажиллагааг дэмжсэн манлай иргэн, манлай байгууллага, манлай сум болох

#### **НЭГ. Хүний хөгжлийн бодлого**

##### **1.1 Орлоготой иргэн**

1.1.1. Өрхийн бичил бизнесийг дэмжиж, хүүгүй, барьцаагүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг үргэлжлүүлнэ.

1.1.2. Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.1.3. Сум багийн хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.

1.1.4. Иргэдийн туршлага, ур чадвартаа түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээл авахад нь бүх талаар дэмжиж ажиллана.

1.1.5. Анх удаа байр авч байгаа бага, дунд орлоготой иргэдэд 3-8 хувийн хүүтэй орон сууцны ипотекийн зээл олгох бодлого орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.

## 1.2 Эрүүл иргэн

1.2.1 Хүүхэд, ялангуяа нялхсын эндэгдлийг тууштай бууруулж, “Хүүхдэд ээлтэй сум болох” зорилтыг үргэлжлүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлнэ.

1.2.2 Иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.2.4 Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.

1.2.5 “Элэг бүтэн Монгол”, “Эрүүл шүд”, “Умайн хүзүүний хавдаргүй Монгол” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ.

1.2.6 Эмнэлгийн ажиллагсдын нийгмийн асуудал, ажиллах орчинг сайжруулан, сумын эрүүл мэндийн төвийг ажилтан, мэргэжилтнээр бүрэн хангана.

1.2.7 Сумын эрүүл мэндийн төвийг халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно.

## 1.3 Чанартай боловсрол

1.3.1 Дотуур байрыг хүүхдийн сурах, хөгжих, эрүүл аюулгүй ээлтэй орчин болгон, хүчин чадлыг бүрэн ашиглаж, 6 настай хүүхдийн амьдрах сурах нөхцөлийг сайжруулна.


1.3.2 Сургуулийн номын санг “*Цахим номын сан*” болгож, утасгүй интернэтийн орчинг нэмэгдүүлнэ.

1.3.3 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, иргэдийн оролцоотой хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлнэ.

1.3.4 Цэцэрлэг, сургуулийн үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар малчдын орлогын тогтвортой байдлыг хангана.

1.3.5 Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн мэдлэг чадвар ажлын гүйцэтгэл туршлагад нь үндэстлэн холбогдох газарт санал хүргэн ажиллана.

1.3.6 Суралцагчдад сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, мэргэжлээ сонгоход туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйч-мэргэжилтнийг сургуульд ажиллуулна.



1.3.7 Багш, эмч төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.

1.3.8 Сургууль, цэцэрлэгүүдэд өндөр өнжүүлэх анги, бүлэг хичээллүүлэхийг дэмжинэ.

1.3.9 Хичээлээс гадуурх сургалтын үндэсний хөтөлбөрийн дагуу сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дугуйлангийн үйл ажиллагааг нэмэгдүүлнэ.

1.3.10 Улс, аймаг, сумын түвшинд зохион байгуулагдажбуй олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож, амжилт үзүүлсэн суралцагч, багш, багийг дэмжиж урамшуулна.

#### **1.4 Тогтвортой-амар, амгалан гэр бүл**

1.4.1 Жирэмсэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд онцгой анхаарч, ургийн эрт үеийн оношилгоонд, жирэмсний хяналтад бүрэн авч, сургалт арга зүйгээр хангана.

1.4.2 Эмэгтэйчүүдийн үүсгэл санаачилгын клуб, холбоо, нөхөрлөл ТББ-дыг бодлогоор дэмжин хамтран ажиллана.

1.4.3 Эмэгтэйчүүдийн нийгмийн оролцоог дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

1.4.4 Ганц бие, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэхэд дэмжинэ.

1.4.5 Баялаг бүтээгчдийг төрийн бодлогоор дэмжинэ.

1.4.6 Орон нутгийн төрийн байгууллагаас үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдийн хөдөлмөрийг үнэлж, дүгнэнэ.

1.4.7 **Сумын нэг өдөр** – үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулж, сумын брендийг нэр төрлийг нэмэгдүүлж, баялаг бүтээгчдээ дэмжинэ.

1.4.8 Төрийн худалдан авалтанд сумынхаа баялаг бүтээгч, үйлдвэрлэгчдээ давуу эрх олгох, зарчим баримтална.

1.4.9 Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох аргачлалыг үндэслэн нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

1.4.10 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

1.4.11 Их, дээд сургууль төгссөн залуучуудаа сумандаа эргэн ирж ажиллаж хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж, цахим мэдээллийн систем, хөдөлмөрийн мэдээллийн санг бий болгоно.



1.4.12 Өрхийн аж ахуй эрхлэх үүсгэл, санаачилгыг дэмжиж, төсөл хөтөлбөрт хамруулж, амьжиргааг нь дээшлүүлнэ.

### **1.5 Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр**

1.5.1 Хүүхдийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг, вакцинд тогтмол хамруулж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

1.5.2 Нүүдлийн болон зуны цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, үргэлжлэх хугацааг уртасгаж, цэцэрлэгт хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

1.5.3 “Хүүхдийн амьдрах, сурах, хамгаалагдах, хөгжлийг дэмжих чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрүүдийг нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн тодорхой хувийг хүүхдийн төлөө үйл ажиллагаанд зарцуулна.

1.5.4 Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшлийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

1.5.5 Хүүхдийн эрх, хөгжил, хамгааллын тогтолцоог бэхжүүлж, хүүхэд, гэр бүлд ээлтэй, тэгш боломж бүхий нийгмийн хамгааллын бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.5.7 Хүүхдийг зам тээвэр, ахуйн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд зорчих авто замын дагуу гэрэлтүүлэг хийж тэмдэгжүүлэх, хурд сааруулагч, камертай болгоно.

1.5.8 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, шинээр тоглоомын талбай барьж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.

### **1.6 Залуучуудыг дэмжих чиглэлээр**

1.6.1 Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин нөхцлийг сайжируулна.

1.6.2 Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.

### **1.7 Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийг дэмжих чиглэлээр**

1.7.1 Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, хамрагдах иргэдийг бүрэн хамруулж, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

1.7.2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, хөдөлмөрэрхлэлтийг дэмжих үйлчилгээнд зорилтот бүлгийн өрхийг нэн тэргүүнд хамруулж, өрхийн орлогыг нь нэмэгдүүлнэ.





1.7.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөгжүүлэх, хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

1.7.4 Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэд хэрэгцээт үйлчилгээгээ авах нөхцөлийг төрийн болон бусад бүх байгууллагад бүрдүүлнэ.

## 1.8 Ахмадуудад үзүүлэх үйлчилгээний чиглэлээр

1.8.1 Ахмадын зөвлөх үйлчилгээг бий болгож, хүүхэд залууст ажлын дадлага, туршилга, мэргэжлийн ур чадварыг өвлүүлнэ.

1.8.2 Ахмадын талаарх төрийн бодлого хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.

1.8.3 Төрөөс олгож буй хөнгөлөлт, урамшуулаллыг ахмадууд цаг алдалгүй хүргэж ажиллана.

1.8.4 Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрөөх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлж, ахмадын өргөөний орчин, нөхцлийг сайжруулна.

1.8.5 Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.

## 1.9 Үндэсний бахархал, өв соёл, спорт

1.9.1 Соёлын төвийн барилга байгууламж, орчин нөхцөл, техник хэрэгсэл, материаллаг баазыг бэхжүүлж, иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмж, давтамжийг нэмэгдүүлэнэ.

1.9.2 Орон нутагт тэргүүлэх чиглэлийн болон үндэсний спортын төрлүүдийг түлхүү хөгжүүлж, нийтийг хамарсан спортын арга хэмжээг өргөжүүлнэ.


1.9.3 Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлж, Монгол бичгийн олимпиадыг иргэдийн дунд уламжлал болгон явуулна.

1.9.4 Хөдөөгийн багуудын “Мэдээллийн төв”-үүдийг засварлан тохижуулж, биеийн тамирын задгай талбайг баг бүрт засварлан тохижуулна.

1.9.5 Орон нутагт Монголынхоо нүүдлийн соёл иргэншил, үнэт зүйлийг танилцуулсан өв, соёл, урлаг, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

1.9.6 Түүх, соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.

1.9.7 Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлүүдийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлнэ.



1.9.8 Биеийн тамир, спортын арга зүйчийг чадвахжуулан ажлын байрыг тохижуулж үйл ажиллагааг өргөжүүлэн чанаржуулна.

1.9.9 Биеийн тамир, спортод хөрөнгө оруулалт хийсэн хувь хүн, аж ахуйн нэгжийг дэмжиж ажиллана.

## **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

### **2.1 Мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл**

2.1.1 Мал эмнэлэгийн салбарын ажил үйлчилгээнд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, автомашин, барилга байр бүхий танхим бий болгох.

2.1.2 Хувийн хэвшлийн мал эмнэлэгүүдийг бэхжүүлж, мал амьтны гаралтай өвчний голомтыг устгах, ариутгах, халдваргүйжүүлэх, ажлын чанар үр дүнг дээшлүүлж, мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулна.

2.1.3 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулна.

2.1.4 Малчид, тариаланчдын нийгмийн асуудлыг шийдэж, уулзалт зөвөлгөөнийг хийнэ.

2.1.5 Мал, амьтны гаралтай арьс, шир, үс, ноос, ноолуурыг боловсруулах жижиг цех, үйлдвэрийг бодлогоор дэмжин төсөл хөтөлбөрт хамруулна.

2.1.6 Зудын эрсдлийг даван туулан “ӨВӨЛЖӨӨ” төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ

2.1.7 Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, малын гаралтай бүтээгдэхүүний цахим тогтолцоог өргөжүүлнэ.


2.1.9 Сүүний чиглэлийн үхрийн эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын сүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг өсгөж, сүүгээ борлуулж буй малчдад сүүний урамшуулал олгох төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлнэ.

2.1.10 Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэн дотоодын хэрэгцээг бүрэн хангана.

2.1.11 Хүлэмж, агуулахын аж ахуйг нэмэгдүүлэх замаар хүнсний ногооны дотоодын хэрэгцээг жилийн турш тогтвортой хангах боломжийг нэмэгдүүлнэ.

2.1.12 Малын тэжээлийн үйлдвэрийг үйл ажиллагаанд зээлийн дэмжлэг үзүүлж, сумын өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ.

2.1.13 Сумын эдийн засагт нөлөө үзүүлэхүйц, орон нутгийн түүхий эдэл түшиглэсэн томоохон болон жижиг дунд үйлдвэрлэлүүдийг хөгжүүлж,



дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг 2024 оныхоос 50%-р нэмэгдүүлнэ.

2.1.14 Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг түлхүү хэрэглэхийг иргэддээ уриалж, төрийн худалдан авалтанд орон нутгийн үйлдвэр, бизнес эрхлэгчид оролцохыг дэмжинэ.

2.1.15 Цэцэрлэг сумын 2024-2028 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

2.1.16 Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаад дотоодын төсөл арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэрийг үр дүнтэй ашиглана.

2.1.17 Орон нутагт хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөж, сум хөгжүүлэх сан болон орон нутгийн хөгжлийн сан, бусад сангуудын үйл ажиллагааг сайжруулан, хөгжлийг дэмжих бодлого баримтална.

2.1.18 Хөдөөгийн багуудын үүрэн холбооны чанар хүртээмжийг сайжруулна.

2.1.19 Орон нутагт бизнес эрхлэгчдийг төрийн бодлогоор дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.

2.1.20 Барилгын материалын үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажиллана.

2.1.21 Хог хаягдалыг ангилан ялгадаг болох талаар сургалт сурталчилгаа хийж, байгаль орчинд ээлтэй устгаажлыг эхлүүлнэ.

## **2.2 Аялал жуулчлал**

2.2.1 Аялал жуулчлалыг сумын эдийн засгийн туслах салбарын нэг болгон хөгжүүлэх тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ.

2.2.2 Дотоодын амрагч, аялагчдад зориулсан амралт зугаалгын бүсчлэлийг тогтоож, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, гар урлалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

2.2.3 Байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдийг түшиглэсэн тогтвортой эко аялал жуулчлалыг сумандаа хөгжүүлнэ.

2.2.4 Аялал жуулчлалын гол чиглэлийн маршрутын дагуу жуулчны отог байгуулахаар зөвшөөрөл хүссэн иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж, тогтмолжуулна.

## **2.3 Төсөв санхүү**

2.3.1 Төсөв санхүүгийн шинэчлэлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, санхүүгийн албаны ажилтнуудын чадавхыг дээшлүүлнэ.



2.3.2 Төр, хувийн хэвшлийн статистик мэдээллийн санг бүрдүүлж, хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, тооцооллыг сайжруулна.

2.3.3 Төсвийн үр ашиггүй зардлыг танаж, хэмнэлтийн горимд шилжүүлж, төсвийг үр дүнтэй зарцуулна.

2.3.4 Татвар хураалтыг цахимжуулж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлж, Малын тоо толгойн албан татварын зарцуулалтыг ил, тод болгож, малчдад тайлагнадаг процессийг сайжруулна..

2.3.5 Шинээр ажлын байр нэмэгдүүлсэн иргэд, аж ахуйн нэгжийг дэмжиж, урамшуулна.

### **ГУРАВ .Ногоонхөгжлийнбодлого**

#### **3.1 Баталгаат ундны ус**

3.1.1 Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн талаас доошгүй хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авна. Тусгай хамгаалалтын газар, сав газрын захиргаатай тогтмол хамтран ажиллаж үйл ажиллагааг дэмжинэ.

3.1.2 Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг өргөтгөж, баталгаат ундны усаар хангана.

3.1.3 Гадаргын усны урсацыг сайжруулж төслүүдийг хэрэгжүүлнэ.

#### **3.2 Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал**

3.2.1 Иргэд, хүүхэд залуучуудад экологийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлж, “*Ногоон соёл- иргэншил*” сумын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.

3.2.2 Ойн хөнөөлт шавьжийн тархалт, өсөлт, бууралтыг хяналтанд авч, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор түүнтэй тэмцэх ажлыг эрчимжүүлнэ.

3.2.3 Гол горхи, булаг шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлж, нутаг дэвсгэрийн рашаануудын химийн найрлагыг тогтоолгоно.

3.2.4 Цаг агаарын мэдээ, мэдээллийг цахимжуулах олон нийтэд хүргэх, түгээх, ажлын чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

3.2.5 Газарзүйн мэдээллийн системд суурилсан “Ухаалаг, цахим газрын зураг” үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно.

3.3.6 Сумын төвийн ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

#### **ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ, СУМЫН ТӨВИЙН ТОХИЖИЛТЫН БОДЛОГО**

4.1.1 Засаг Даргын Тамгын Газрын барилга шинээр бариулна.

4.1.2 Хог хаягдлыг байгальд халгүй аргаар устгах технологи, менежментийг судлан хэрэгжүүлж эхлэнэ.

4.1.3 Сумын төв зарим хөдөөгийн багийн хүн амыг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, үүрэн телефоны мэдээлэл дамжуулах үйлчилгээний технологийг нэвтрүүлнэ.

4.1.4 Сумын төвийн иргэдийн аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлж, авто зам, гудамж, олон нийтийн зам талбайг гэрэлтүүлэх камержуулах ажлыг үргэлжлүүлнэ.

4.1.5 Сумын төвийн дулаан, цахилгааны найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлж, удирдлага менежментийн ухаалаг шийдлийг нэвтрүүлнэ.

4.1.6 Гудамж, байшин барилгын хаягийн нэгдсэн стандартыг нэвтрүүлнэ.

4.1.7 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орон нутгийн нийтлэг шаардлагад нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулж, газар зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсронгуй болгон мөрдөнө.

4.1.8 Тэсийн-Илч ХХК-ны дулаан үйлдвэрлэх зуухыг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэн зуухны янданг утаа шүүлтүүртэй болгож, агаарын бохирдлыг бууруулна.

4.1.9 Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагыг инженерийн шугам сүлжээ бүхий тохилог орон сууц, эдэлбэр газар, амины орон сууцтай болох нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

4.1.10 Орон нутгийн чанартай зам, давааг засч сайжруулна.

4.1.11 Сумын төвийн халуун усны тоог нэмэгдүүлнэ.

4.1.12 Тэсийн гол дээр бетонон гүүр бариулна.

4.1.13 "Хийморь" төслийг үргэлжлүүлнэ.


## **ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО**

5.1.1 Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж ажиллана.

5.1.2 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж E-Mongolia системийг сурталчлан ажиллана.

5.1.3 Хүнд сурталгүй төрийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулж, төсвийн зардлыг хэмнэнэ.

5.1.4 Газарзүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.



5.1.9 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

5.1.10 Төр, иргэний нийгэм болон бизнесийн байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлага төлөвшүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх мэдээллийг урамшуулах эдийн засгийн болон бусад хөшүүргийг бий болгоно.

5.1.11 Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.

5.1.12 Төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг орон нутаг, төрийн албаны анхан шатны нэгжид ажиллуулан дадлагажуулах замаар мэдлэг чадвар, туршлагыг нэмэгдүүлнэ.

5.1.13 Сумын төвийн гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.

5.1.15 Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, орон нутгийн авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтыг сайжруулна.

5.1.16 Хүн амын хүнсний болон эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах зорилгоор гарч буй зөрчил дутагдлыг арилгах, хяналт тавих үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

5.1.17 Гамшигт үзэгдлүүд (ган зуд, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.

5.1.18 “**Иргэний танхим**”-ыг техник тоног төхөөрөмжөөр хангаж, иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, мэдээлэл сурталчилгааны ажлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.1.19 Нийгмийн дэг журам хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар 2024-2028 оны төлөвлөгөө гарган түүнийг үе шаттай хэрэгжүүлнэ.

5.1.20 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог дээшлүүлж, хамтын ажиллагааг сайжруулж, гэмт хэргийн гаралтыг тогтвортой бууруулна.

5.1.21 Цагдаагийн тасгийн хүний нөөц, чадавхийг бэхжүүлж, үйл ажиллагааг нь сайжруулж, иргэдийн дунд хуулийн байгууллагад итгэх итгэлийг дээшлүүлж, нэр хүндийг өсгөнө.

5.1.22 Орон нутагт ажиллах багш, эмч, төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн тогтвор суурьшилтай ажиллуулна.

**ЦЭЦЭРЛЭГ СУМЫН  
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

